

БАЙГУУЛЛАГЫН 2025 ОНЫ ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ
ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН
“ТАЙЛАНГИЙН МАЯГТ”¹

НЭГ. Товч танилцуулга²

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Оюуны өмчийн газар нь Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуульд заасны дагуу нийт албан хаагчдыг саналыг үндэслэн тус газрын даргын 2024 оны 09 сарын 04-ний өдрийн А/105 дугаар тушаалаар Оюуны өмчийн газрын ёс зүйн дэд хороог 5 гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулсан. Тус газрын Ёс зүйн дэд хорооны даргаар Захиргаа удирдлагын газрын дарга Г.Гантулга, гишүүдээр Аж үйлдвэрийн өмчийн газрын бүтээгдэхүүний загварын ахлах шинжээч О.Оюунгэрэл, Зохиогчийн эрхийн газрын ахлах мэргэжилтэн Ч.Эрдэнэбаяр, Хяналт, шалгалтын газрын улсын байцаагч Б.Золбаяр, нарийн бичгийн даргаар Захиргаа удирдлагын газрын эрх зүй, хүний нөөц хариуцсан ахлах мэргэжилтэн Б.Далайцэрэн нар ажиллаж байна.

ХОЁР. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар

2.1.Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт³:

Ёс зүйн дэд хорооны 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хөтөлбөрийн шалгуур үзүүлэлттэй нийцүүлэн баталсан. Мөн Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрдлийн үнэлгээг хийж ажилласан болно.

1.Ёс зүйн хорооноос зохион байгуулсан ёс зүйн дэд хорооны гишүүдэд зориулсан “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн хэрэгжилт” вебинар сургалт, “Ёс зүй ба хүний эрх” зорилтод сургалтад тус газрын ёс зүйн дэд хорооны дарга, нарийн бичгийн дарга, гишүүд хамрагдсан.

2.Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэстэй хамтран "Авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн албан хаагчийн ёс, зүй" сэдэвт сургалтыг тус газрын албан хаагчид болон Оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчид, хамтын удирдлагын байгууллагын гишүүдэд сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулсан.



¹ Маягтын дагуу тайланг 5 хуудаснаас ихгүй, товч үр дүнг нэгтгэн ирүүлнэ.

² Байгууллагын харьяа салбар, нэгжийн хэмжээнд Төрийн албан хаагчийн ёс зүйн нийтлэг хэм хэмжээг сахиулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, зөрчил гаргасан эсэхийг хянан шалгаж, дүгнэлт гаргах, төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийх байдлын талаар товч мэдээллийг тайлагнана.

³ Улсын Их Хурлын 2024 оны 27 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх хүрээнд зохион байгуулсан үйл ажиллагааны талаар тайлагнана.

3.Сэтгэл зүйч Ж.Үйлсттэй хамтран тус газрын албан хаагчдад “Стресс менежмент, ажлын байрны сэтгэл зүй” сэдвээр 2025 оны 04 дүгээр сарын 02-ны өдөр сургалт зохион байгуулсан.



4.Залуусын цахим орчин дахь аюулгүй байдалд голлон анхаарч, технологийг аюулгүй, ёс зүйтэй ашиглахыг дэмжин, зорилгоор Монголын баримт шалгах төвийн ерөнхий эрхлэгч Э.Батцэцэг, баримт шалгагч, сэтгүүлч Г.Мөнхтунгалаг нартай хамтран 2025 оны 12 дугаар сарын 05-ны өдөр Оюуны өмчийн газрын албан хаагчдад сургалт зохион байгуулсан.



2.2.Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал:

а). 2025 онд байгууллагын үйл ажиллагаа, албан хаагчийн ёс зүйтэй холбоотой гомдол мэдээлэл бүртгэгдээгүй бөгөөд нийт гомдол мэдээллийг <https://www.ipom.gov.mn/mn.php?page=115> дамжуулан олон нийтэд мэдээлж байна.

б). Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайланг <https://www.ipom.gov.mn/mn.php?page=155> цахим хуудсанд байршуулсан.

в). Шударга, ил тод, хариуцлагатай төрийн албаны соёлыг төлөвшүүлэн, ёс зүйн хэм хэмжээг сахих, жендэрийн эрх тэгш байдлыг хангах, ажлын байрны аливаа хэлбэрийн дарамтаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг явуулж, албан хаагчид аливаа гэмт хэрэг, зөрчлийн талаар мэдээлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх хүрээнд газрын даргын 2025 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн А/118 дугаар тушаалаар Оюуны өмчийн газрын Хөдөлмөрийн дотоод журамд нэмэлт өөрчлөлт оруулж, “АРВАН ДӨРӨВ. АЛБАН ХААГЧААС ИРҮҮЛСЭН ГОМДОЛ МЭДЭЭЛЛИЙГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ” бүлгийг нэмсэн.

г). Тус газрын даргын 2024 оны 09 сарын 04-ний өдрийн А/105 дугаар тушаалаар Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа, гишүүдийг урамшуулах санхүүгийн их үүсвэрийн шийдвэрлэсэн.

2.3. Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа:

а). “Төрийн албаны хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо” цахим системд Ёс зүйн дэд хорооны гишүүдийн бүртгэлийг хөтөлж, Монгол Улсын Ёс зүйн тухай хууль, холбогдох журам, Үндэсний хөтөлбөр зэргийг дотоод сүлжээгээр дамжуулан албан хаагчдад мэдээлсэн бөгөөд 2025 онд шинээр томилогдсон 1 албан хаагчид зөвлөмж боловсруулж танилцуулсан.

б). Төрийн албан хаагчаас ирүүлсэн гомдол мэдээлэл бүртгэгдээгүй.

в). Ёс зүйн чиглэлээр постер бэлтгэж олон нийтэд суртчилах ажлыг зохион байгуулсан.



Гарсан үр дүн, ололт амжилт:	Бэрхшээл:
Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдол мэдээлэл бүртгэгдээгүй, хянан шалгах чиг үүргийн хүрээнд холбогдох этгээдэд шилжүүлсэн гомдол мэдээлэл байхгүй. 2024 оны Шударга байдлын үнэлгээнд 81 байгууллага хамрагдсанаас "Оюуны өмчийн газар" тэргүүлсэн амжилт гаргасан.	Байхгүй.
Санал:Үгүй.	

2025 оны 12 сарын 18-ны өдөр